



БАТЛАВ.

ДАРГА *[Signature]* Г. МАНЛАЙЖАВ

2022 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр

ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН АЖЛЫН АЛБАНЫ 2022 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

Дэд хэсэг	Хийх ажлын агуулга	Шалгуур	
		Гүйцэтгэлийн үзүүлэлт	Хугацаа
1.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах	Байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт авлигын эсрэг үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн баримт бичиг, мэдээ мэдээллийг тухай бүрт байршуулна.	I-IV улирал
2.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох	Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, Цөмийн энергийн комиссын нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон тогтоолын төслийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг хүлээн авах боломжийг бүрдүүлнэ.	I-IV улирал
3.	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх /цахим хуудсаар/	Шилэн дансны тухай хууль, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын дагуу 2022 оны төсвийн гүйцэтгэл, 2022 оны төсвийн сар бүрийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, төсвийн зарцуулалт, түүнтэй холбоотой тушаал болон төсөв, санхүүтэй холбоотой үйл ажиллагааг холбогдох журмын дагуу цахим хуудсанд дээр байршуулах ажлыг зохион байгуулна.	I-IV улирал
4.	Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах	Цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн, байгууллагаас батлан гаргасан дүрэм, журмыг байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтэд танилцах боломжоор хангана.	I-IV улирал

5.	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах, Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэх	Сул орон тооны зарыг цахим хуудсанд байршуулах, сонгон шалгаруулалт явах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлана.	I-IV улирал
6.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах	Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, холбогдох бусад мэдээллийг цахим хуудсанд байрлуулна.	I-IV улирал
7.	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх	Ёс зүйн дүрмийг байгууллагын албан хаагчдад мөрдүүлнэ.	I-IV улирал
8.	Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах	Эрх бүхий албан тушаалтнаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамруулснаас бусад шийдвэрийн мэдээлэл, үйл ажиллагаандаа мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм, журмыг байгууллагын цахим хуудсанд байршуулна.	I-IV улирал
9.	Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах	Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах, өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шуурхай шийдвэрлэнэ.	I-IV улирал
10.	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах	Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах, холбогдох арга хэмжээг зохион байгуулна.	I-IV улирал
11.	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх	Авлигатай тэмцэх газраас хууль тогтоомжид заасан эрх үүргийн хүрээнд ирүүлсэн зөвлөмж, албан бичгийн биелэлтийг зохион байгуулна.	I-IV улирал
12.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх	Байгууллагын албан хаагчдад Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль зэрэг,	I-IV улирал


	тухай хууль, Авлигын эсрэг хуулийг сурталчлах	бусад шаардлагатай мэдлэг мэдээллийг өгч ажиллана.	
13.	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах	Сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж, сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо гарсан байна.	I-IV улирал
14.	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, санаачилга өрнүүлэх	-Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд нэгдсэн байна; -Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах, аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна.	I-IV улирал

#### АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ САНАЛ, САНААЧЛАГА

Хийх ажлын агуулга	Шалгуур	
	Гүйцэтгэлийн үзүүлэлт	Хугацаа
Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх	Төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнах	I-IV улирал
Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт	Авлигатай тэмцэх чиглэлээр удирдлагын зүгээс арга хэмжээг авч хэрэгжүүлэх	I-IV улирал
Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх	Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах	I-IV улирал

БОЛОВСРУУЛСАН:

ЦӨМИЙН ТЕХНОЛОГИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН  
ДАРГА, ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

 М. ЧАДРААБАЛ